

Монгол-Манж толь бичгийн уламжлал дахь нэгэн дурсгал

М. Баярсайхан*

Монгол хэлтний толь бичгийн уламжлал нь нангиад сурвалжийн мэдээгээр наанадаж Сяньби улсын үеэс эхтэй тухайд судлаачид тэмдэглэжээ.¹ Бидний үед өв болж үлдсэн анхны монгол хэлний толь бичгүүд нь монголчуудын сүр хүчин, үүрэг нөлөө үлэмж байсан түүхэн нөхцөл байдалтай уялдан монголыг судлах хэрэгцээ шаардлагаар хятад, араб, перс хэлтний бий болгосон 14-15 дугаар зууны үеийн бэсрэг толь бичиг хийгээд түүвэр үгийн орчуулга сэлт юм. Тэдгээр нь дундад үеийн монгол хэлний үгийн сан төдийгүй нутгийн аялгуу, авианзүй, хэлзүйн зарим онцлогийг тодруулан гаргах хэлний чухаг дурсгал болно. Мөн Юань улсын үед монгол хаадын зарлигаар монгол бичгийн мэргэд оролцсон нангиад, солонгос,² түрэг, төвд зэрэг Юань улсын бүрэлдэхүүн дэх үндэстнүүдийн хэл хийгээд монгол хэлний орчуулгын толь гарч байсан байх магадлалтай. Гэвч орчин цагийн монгол толь бичгийн хөгжилд бодитой ул суурь нь болох буюу илүү түлхүү нөлөөлсөн нь Чингийн үед гарсан манж монгол толийн уламжлал болно.

Манж хэлний толь бичгийг 1673 оноос үүсгэжээ. Энх-Амгалан хааны зарлигаар манж бичгийн мэргэдийн туурвисан тэрхүү “Хааны бичсэн манж үгний толь бичиг”³-ийг 1708 онд сая дуусган ордны бар сийлэн тархаасан байна. Мөн тэрхүү манж үгний тайлбар толийн эш татсан эртний бичиг зохиолын үгийг нь хасаж, зарим газар найруулгыг ялимгүй өөрчлөөд Энх-Амгалан хааны зарлигаар Рааш, Данзан, Авид нарын 16 монгол бичгийн түшмэл монголчилон хадсан нь “Хорин нэгт тайлбар толь” гэж алдаршсан “Манж монгол үгний толь бичиг” юм. Чингэж “Хааны бичсэн манж үгний толь бичиг”-т монгол үг хадах ажлыг 1710 оноос эхэлж 1717 онд дуусган ордны бар сийлжээ. Энэ нь монгол хэлний анхны

* Монгол Улсын Их Сургууль, *Монгол Хэл Соёлын Сургууль*

¹ Ц.Шагдарсүрэн, *Толь бичгийн судлал: //Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс* /УБ., 1986 он/ хэмээх номын III бүлэг. 191т.

² Солонгос хэлтэн ханз үсэг хэрэглэж байсан тул ханзны толь нь нангиад ба солонгост нэгэн зэрэг хэрэглээ хангаж байв.

³ Манжаар “Han-i araha manju gisun-i buleku bidhe” хэмээх энэ толийг Фү Да Ли, Ма Чи, Мархан зэрэг бичгийн түшмэл удирдан хийжээ. Үүнийг 1775 оны “Дөрвөн их бичгийн бүрэн эмхэтгэлийн товч дэвтэр” хэмээхэд оруулсан ба харин 1784 оны “Дөрвөн их бичгийн бүрэн эмхэтгэл”-д оруулаагүй ажээ.

тайлбар толь төдийгүй урьд урьдынхаас илүү багтаамжтай монгол хэлний орчуулгын толь болсон юм. Нийт 12 000 орчим толгой үг бүхий нь тухайн үед авч үзвэл хэмжээний хувьд иххэн бөгөөд анхдагч болохын хувьд нэлээн цаг хүч шаардсан бүтээл болно. “Хорин нэгт тайлбар толь” бол манж-монгол, хятад-монгол хэлний орчуулгын бүхий л толь бичиг, гурван хэлний, дөрвөн хэлний, таван хэлний толь бичиг, өнөөг хүргэл гараад буй монгол хэлний олон тайлбар толь, монгол үсгийн зөв бичих зүйн толиудын эх үндсийг нь шууд болон дам байдлаар тавьсан чухам суурь бүтээл билээ. Сумадирадна бээр “Төвд монгол дохионы бичиг”⁴-ээ найруулахдаа мөн л “Хорин нэгт тайлбар толь”-ийг тулгуур сурвалж болгон ашигласан нь илэрхий ажиглагддаг. Монгол толь бичгийн судлалд энэ толийн түүхэн ач холбогдол, үнэ цэнийг бүрэн зөв үнэлэх хэрэгтэй.

Манж, монгол хоёр хэлний толь бичгийн уламжлалыг авч үзвэл манж толгойтой толь давамгайлж ирсэн байна. Монгол толгойтой манж толь эдүгээ мэдэгдэж буйгаар “Монгол үсгийн хураасан бичиг” хэмээх монгол нангиад манж толь бичгээс өөр тоймтой, нийтэд тархаж дэлгэрсэн нь үгүй билээ. Үүнийг Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны түшмэл Сайшанга⁵ 1851 онд зохиосон хэдий ч огт хэвлэгдэлгүй хадгалагдан байсныг 1891 онд мөнхүү жургаанаас айлтгасанд, зарлиг буулгаж Киншо, Сюйлян нараар удирдуулсан арав гаруй түшмэл манж монгол нангиад гурван зүйлийн үсэг хавсарсан толь, үзэхүйд хялбар болгосон бичиг тэргүүтнээс шүүрдэн нэмж нөхөх ажлыг гүйцэлдүүлээд модон бараар хэвлүүлсэн аж. Монгол газрын аливаа албан бичиг хэргийн үгийг тэрхүү “Зарлигаар тогтоосон монгол үсгийн хураасан бичиг”-ээр журам болгож даган шийтгэж байхыг Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамнаас тушааж байсан ба Монгол дахь төрийн болон гэрийн сургуульд хэрэглэж байжээ. Бас манж үгийг орчуулах гарын авлага болгон энэ толиос хуулж сийрүүлсэн, монгол толгой үгээр эхэлсэн гар бичмэл багавтар дэвтрүүд тархаж байжээ. Тэгвэл Сайшанга-гийн дурдсан толь бичгээс өмнө Халхад нэгэн Монгол-Манж толь бичиг гарч байжээ.

Тус бяцхан өгүүлэлд урьд өмнө судлаачдад нэр дуулдаагүй асан тэрхүү толь бичгийн тухай танилцуулахыг зорив. Эл толь бичиг МУИС-ийн манж хэлний багш агсан Ц.Шархүүгийн хувийн хадгаламжинд байсан бөгөөд эдүгээ МУИС-ийн Монгол Хэл Соёлын Сургуулийн Эх бичиг-Алтай судлалын тэнхимийн номын санд буй. Ц.Шархүү багш энэ толийн талаар ямар нэгэн танилцуулга тодорхойлолт хараахан нийтлүүлж амжаагүй бололтой байна. Толь бичгийн оршилд зохиогч Халхын Түшээт хан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж Дондовдорж хэмээн нэрээ бичжээ. Тэр бол мөнхүү аймгийн бэйлийн зэрэг Дайчин засгийн хошууны⁶ дээд тав дахь үеийн ноён, 1822 онд засаг ноён залгамжилсан, тэргүүн зэрэг тайж Дондовдорж болно. Кирилл бичгээр хөрвүүлсэн “Монгол улсын шастир”-т Дондовдоржийн нэрийг Түдэвдорж хэмээн ташаа бичсэн байна. Үсгийн дүрс ч тэгэж халгуурах боломжтой

⁴ Бүтэн нэр “Төвд монгол дохионы бичиг, нэр, үг, утга гурвыг тодруулан харанхуйг аригшач зүл нэрт оршиг”

⁵ Энэхүү Сайшанга нь багаас монгол хэл бичиг заалгасны дээр Сайр усны өртөөний хэргийг захиран шийтгэх түшмэлээр зарагдсан өөрийн эцгийг даган 14-17 насандаа монгол газар сууж байжээ. Тэр бээр эцгийн бичсэннийг засан нэм нэмсээр “Монгол үсгийн журмыг салгасан бичиг” /monggo hergen-i juran-be faysalaha bidhe/ хэмээх манж нангиад монгол толь бичгийг 1848 онд бичиж дуусгажээ. Иймээс анх 1851 онд бичсэн “Монгол үсгийн хураасан бичиг” бол бараг тэр 1848 оны толийг барьж монгол толгойтой болгон засаж цэгцэлсэн зохиол биз ээ.

⁶ Түшээт хан аймгийн бэйлийн зэрэг Дайчин засгийн хошуу нь одоогийн Төв аймгийн урд захуур, Дундговь аймгийн төв ба хойд сумдын нутгаар савлаж байжээ.

юм. “Монгол улсын шастир”-т бичсэнээр дөрөвдүгээр удаа засаг ноён залгамжилсан Үржинжавын үрчилсэн хөвгүүн. Төр Гэрэлтийн хоёрдугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилж, Төр Гэрэлтийн зургадугаар онд үгүй болсон гэжээ. Мөн Үржинжавыг Төр Гэрэлтийн тэргүүн онд үгүй болсныг тэмдэглэжээ. Тэгвэл толь бичгийн оршилд «Төр Гэрэлтийн хоёрдугаар он намар цагт анх удаа мөн цэргийн хорооны жасаа сууснаас нааш ...» хэмээн бичсэн буй. Цэргийн хорооны жасаа суух үүрэг хошууны засаг ноёдод ногдож байсан билээ. Тэгэхлээр эцэг ноёноо үгүй болсон хойно, 1822 онд засаг ноён залгамжлаад тэр жилийнхээ намар анх удаа жасаанд суусан нь зүйд таарч байна.

Тэр бээр 1824 онд толь бичгээ зохиож төгсгөжээ. Номын гарчигийг дотор тэргүүн нүүрт “*Mongyo hergen i uju deri deribume. dahanduhai manju hergen faidame hetu undu weilefi araha huleku bidhei uju debtelin:*” (Монголчилбол, “Монгол үсгийн толгойгоор эхлэн дагалдаагаар манж үсэг жагсаан хөндлөн гулд үйлдэж бичсэн толь бичгийн тэргүүн дэвтэр”) хэмээн бичсэн бөгөөд дотор 3 дугаар нүүрт мөн “*Mongyo hergen i uju deri ilyame faysalafi hetu undu weilefi faidame arafi. manju gisun i amba muru-be baičame tuwara-de ja obuha bidhei uju debtelin*” (Монголчилбол, “Монгол үсгийн толгойгоор ялган салгаж, хөндлөн гулд үйлдэж жагсаан бичиж манж үгийн их төлвийг байцаан үзэхүйд хялбар болгосон бичгийн тэргүүн дэвтэр”) хэмээн өөр нэр бичжээ. Гэтэл, оршлын үг «*Mongyo gisun-be manjurame ubaliyambure-de ja obuha bidhe serengge. erebe...*» (монгол үгийг манжаар орчуулахуйд хялбар болгосон бичиг хэмээгч үүнийг...) гэсэн үгээр эхэлж байна. Үүнээс үзвэл номын гарчгийг хараахан эцэслэн тогтоогүй байжээ. Магадгүй дахин үзэж нягтлаад нэрийг эцэслэн тогтосны эцэст дээр айлтгаж, зарлигийг эрэхээр саналхийлсэн байж болох юм.

Номыг үйлдэхдээ өндрөөш 26 см, өргөөш 26,5 см хэмжээгээр нугалсан муутуу цаасыг нарийн сураар үдэж товхин, хар бэхээр бийрээр бичжээ. Хуудас дугаарлаагүй. Нийт 124 нүүр буюу 62 хуудастай. Үүнээс 1 ба 3 дугаар нүүр нь дээр дурдсанчилан гарчиг бүхий, 5-9 дүгээр нүүрт оршил, 11 дүгээр нүүрт тус толь бичигт баримталсан цагаан толгойн дэсийг бичиж, 12 дугаар нүүрээс хойш “а” –гаас “нү” толгойг дуусталхи толийн хэсгийг оруулжээ. Нэг хуудсанд 20 мөрөөр гурван эгнээ бичсэн. Өөрөөр хэлбэл, дүүрэн бичигтэй нүүрт нийт 60 толгой үг орчуулгын хамт багтсан байна. Угтаа хоёр дэвтэр хэмээн оршилд бичсэн боловч бидэнд тэргүүн дэвтэр л олоод байна. Оршилыг манж монголоор хадаж бичсэнийг уг байгаагаар нь галиглавал доорхи мэт буюу. (Галигт мөр заах шаардлагагүй гэж үзэв.) Үүнд:

«*Mongyo gisun-be manjurame ubaliyambure-de ja obuha bidhe serengge. erebe qalqai Tusiyetu han Mongyol üge-yi mangju⁷-bar orčiyulqui-dur kilbar bolγaysan bičig kemegči egün-i qalq-a yin Tüsiyetü qan*

aiman i jasay uju jergi taiji Dondobdorji mimbe ongyolo Saičungya fengšen i juwan uyuči āniya-de ayimay-un jasay terigün jerge tayiji Dondobdorji namayi urid Sayisiyaltu irügeltü-yin arban yisüdüger on-dur⁸

ječen-be toytobure hashû ergi aisilara jiyanggiyûn hebei ambasai bači ulame kijayar dakin-i toytaγayči jegün eteged-ün tusalayči jangjun quubi-yin sayid-ud-un γajar-ača ulamjilan

⁷ Зүй нь манжу гэж бичнэ. Ийм заалтыг хойшид [= манжу] хэмээх мэтчилэнгээр дөрвөлжин хаалтад хийж, зүүлтэд оруулав.

⁸ Сайшаалт-Ереолтийн арван есдүгээр он бол аргын тооллын 1814 он буюу.

wesimbufi čohome Enduringge ejen i qalqai geren asihata-be hûwašabure jalin bidhe hergen tačibure ten i ayiladqaju čuqum Boyda ejen-ü qalq-a-yin olan jalayus-i kümüjigülküi-yin tula bičig üsüg suryaqu tuyil-un

γûnin-de ačabume tačire idude dosimbuki seme wesimbuhe-de Hese wesimbuhe songqoi tayalal-dur neyilegülün surqu jisiiyan-dur oruyuluy-a kemen ayiladqaysan-dur Jarliy ayiladqaysan yosuyar

obu sehebe gingguleme dahafi aha Do bi čoochai qûwaran-i bade ninggun aniya tefi aisilaqû bolγ-a kemegsen-i kičiyenggüilen dayaju boyol Do bi čerig-ün qoriyan-u γajar-a jiryuyan jil sayuju tusalaqu

hafan loyišeng deri bidhe hergen jorišaha. Fûniči mini ere sefu serengge niyalma ningge tondo ulhingge tûsimel loyišeng-iyer bičig üsüg jiyalyaba. Sanabasu minu ene baysi kemegči kümün anu siduryu uqayan

getuken. niqan manju hergen bidhede urehe. kemuni tuwači qalčunggi segtu niyalma bihe. Damu todurqai. kitad mangju üstig bičig-tür bolbasuraysan. basakü üjebesü čoy tai sergüleng kümün bültige. Gayčakü

mini ufuhi hesebun ningge juken gen yan aqû jači hûlhi lampa bime. fuhali tačihaqû minu qubi jayayan inu jekei uqayan seke-e [=sekege] ügei dangči mungqay balar böged. tung suruysan ügei

bičibe mentuhun beyebe bodoraqû fuhašame γûniči mongyo gisun-be manjurame ubaliyambure-de bolbaču mungqay beyeben bodoqu ügei ergičegülün sanabasu mongyol üge-i [=yi] mangjučilan [=manjučilan] orčiyulqui-dur

umesi mangya. sere angyala. teni tačire juse sarqû gisun teisuleči bahafi. tuwara-de ja masi berke. geküčü bayituyai. sai [=sayi] surqu keüked ülü medekü üge tokiyaldubasu olju üjeküi-dür kilbar

okin i seme γûnifi. ilan hačın i gisun qamčibume arafi tuwara-de ja obuha bidhe-be mongyo boltuyai kemen sanaju. γurban jüil-ün üge qabsuryulun [=qabsuryayulun] bičijü üjeküi-dür kilbar bolγaysan bičig-i mongyol

uju deri ilγame faysalame aname araki seme γûnin tebuhei. umai nuytei bade baita toluyai-bar ilγan salγaju darayalan bičisügei kemen sanan sayuysayar. yirü [=yerü] nutuy-yin [= -un] γajartur kereg

largin labdu ofi. fuhali arafi jabduhaqû. Te Doro eldengege i jai aniya bolori foryon-de budaliyan [=budaliyan] ülemji bolju. tung bičijü jabdaysan [=jabduysan] ügei. Edüge Törü gereltü-yin qoyaduyar on⁹ namur čay-tur

tuytan mudan inu čoochai qûwaran i idu teheči ebsi ilan mudan terede. siden i baita angq-a uday-a mön čerig-ün qoriyan-u jisiiy-a sayuysan-ača inaysi γurban uday-a sayuqui-dur alban-u kereg

ičihiyara sidende taqa šolo bahafi. teni baičame tuwafi mongyo hergen i emu tangyü uju-be ilγame sidkeküi qoyorundu-dur tür čilüge olju. sai [=sayi] bayičayan üjeju mongyol üstig-yin nigen jayun toluyai-bar ilγan

faysalame a sere uju deri deribume alara gisun-be emu dahanduhai e sere uju deri deribume alara salγaju a kemekü toluyai-bar ekilen kelekü üge-yi nigen dayalduy-a-bar e kemekü toluyai-bar ekilen kelekü

gisun-be inu emu dahanduhai hetu undu weilefi dergi-de mongyo gisun. inu sirame manju üge-yi mön nigen dayalduy-a-bar köngdülen [=köndelen] γuldu üiledčü degedü-dür mongyol üge. mön daray-a mangju [=manju]

⁹ Төр гэрэлтийн хоёрдугаар он нь аргын тооллын 1822 он буюу.

gisun faidame arahabi. Ere ningge damu amaya jalan i juse omosi-be manju gisun-be amba muru-be udhai üge jiysayan bičijüküi. Ene anu [=inü] γaγča qoyiči üy-e yin ketiked ači nar-i mangju¹⁰ üge-yi yeke tölüb-i darui

bahafi sakini, ja tačikini seme udtu uru waqa. waiqû taiqû banjibume arahangge. Kemuni olju medeküi-dür kilbar suratuyai [=surtuyai] kemen eyin kü jöb buruyu. murui qajayai jokiyān bičigsen buyu. basaču

narhün gisun, jai arači udtu. hûlači tudtu hergen i dursun, gisun i mudan jergingge-be aqûmbume arafi, nariin [=narin] üge, jiči eyin bičikü. teyin ungsiqu üsüg-ün dürsü. ügen-ü ayalyu/udaγ-a terigüten-i güiçedken bičijü.

fuhali muteheqû. Erebe giyan i manju bidhe-de urehe looyese hafasa bidhesi sede isitala oγuyu-a ese čidaba. Egün-i jüi inü mangju [=manju] bičig-tür bolbasuruγsan noyad tüsimed bičigeči ner-tür kürtel [=kürtel-e]

we tuwaha niyalma čibtui leulečeme yongkiyafi tuwančihiyame arači ačambi. Jai ere bidhe-be mentuhun Do bi ken üjegsen kümün sayitur sigümjilen бүридкежү jalarayulun bičibesü jokimui. Jiči enc bičig-i tenüg [=teneg] Do bi

ilan aniyai uyun biya otolo umai ališara banuhûšara-be baiburaqû damu sulaha hûlhi γurban jil-yin [=jil-ün] yisün sar-a boltal-a yirü uyidqu jalqaγuraqu-yi ülü kerigsen [=kerigsen] γaγčakü üldegegsen mungqay

γünin-be jiduji tuhembume, juse omosi-de tusa obuki, seme mentuhureme γünifi naranggi γala-či sanay-a-ban erkibisi [=erkebisi] бүтүгежү, кеүкед ачinar-tur tusa болγay-a, kemen mungqaylan sanaju egenigte γar-ača

hoqoburaqû tuwahi, inu araha arahai, teni elei nikedeme dorо eldengge i duiči aniya niowanggiyan bonio qayulal [=qayulul] ügei üjegseger, mön biči bičigseger, sai [=sayi] aria dönggejü törö gereltü-yin dörbedüger on köke bičün¹¹

aniya niyengniyeri dulimbai fulahün γûlmahün biyade šangyabufi, juwe debtelin obufi, yohi obume giyalaha, qabur-un dumdadu ulayayčün taulai saradur tegüskejü, qoyar debter болγaju, iji neyilegülün tobkiba.

Ede bidhe udu labdu bičiibe baičame tuwara-de noqai ja ombi.
Egün-dür bičig kedüi ülemji bolbaču bayičayaju üjeküi-dür teyin kilbar bolumui.

Günin isinaha-be yargiyan-i aqûnaha amba urgun-i niulhun hüturingya sain inenggi.
Sanay-a kürügsen-i ünekerün [=üneker-ün] güiçedkegsen yeke bayar-un ki mori [=kei mori] delgeregsen buyantai sayin edür-e.» ХЭМЭЭЖЭЭ.

Оршилд “гурван зүйлийн үг хавсаргуулан бичиж үзэхүйд хялбар болгосон бичгийг монгол толгойгоор ялган салгаж дараалан бичсүгэй хэмээн санан суусаар...” *lilən hačün i gisun qamčibume arafi tuwara-de ja obuha bidhe-be mongγo uju deri ilγame faysalame aname araki seme γünin tebuhei...* гэж бичсэнийг бид зөв ухаарах хэрэгтэй. Үүнийг нэгд, бичигч өөрөө монгол толгойтой гурван хэлний үг хавсаргасан толь хийхийг зорьсон, хоёрт, урьд гарсан гурван зүйлийн үг хавсаргуулан бичиж үзэхүйд хялбар болгосон бичиг хэмээгчээс монгол толгойг нь ялган салгаж цагаан толгойн дэсээр болгож бичихийг зорьсон гэсэн хоёр өөр утга санаагаар ойлгох бололцоотой байна. Миний үзэж буйгаар хоёрдугаарх утгаар ухаарах нь зүй

¹⁰ [=manju]

¹¹ Төр гэрэлтийн дөрөвдүгээр он хөх бичин жил нь аргын тооллын 1824 он буюу.

мэт. Ингэж үзвэл, оршилд дурдсан “гурван зүйл үг хавсаргуулан үзэхүйд хялбар болгосон бичиг” / *ilan hačin i gisun qatčibume arafi tuwara-de ja obuha bidhe* / хэмээх нь Жин Зай гүн (Утга үнэн гүн) зохиож, 1780 онд түүний хөвгүүн Сю Шэн Фүжюнь үг нэмж, оршил бичсэн “*ilan hačin-i gisun qatčibuha tuwara-de ja obuha bidhe*” / Гурван зүйлийн үг хадмал үзэхүйд хялбар болгосон бичиг/ болно. Цаг хугацааны хувьд ч зөрөх зүйлгүй. Үүнийг нутлах нэгэн баримт гэвэл, энэ хоёр толийн оршлын үг, бүтэц зарим талаар тун ойролцоо байгаа явдал юм.¹² Жишээ болгон дараах харгууллыг үзнэ үү.

- 1780 оны зохиолд: *yurban jüil-ün üge qadamal üjeküi-dür kilbar bolıaysan bičig kemegči*
 1824 оны зохиолд: *mongyol üge-yi mangju-bar orčiyulqui-dur kilbar bolıaysan bičig kemegči*
 1780: *basa eyin bičijü teyin ungsiqu ayalıu adali bolbaču*
 1824: *jiči eyin bičikü. teyin ungsiqu üsüg-ün dürsü. ügen-ü ayalıu/uday-a terigüten-i*
 1780: *ger-ün surqu köbegüd-iyen kilbar-a surtuıai kemen sanaday abču.*¹³ *tung bičijü ese jabduba.*
 1824: *surqu keüked ülü medekü üge tokiyaldubasu olju üjeküi-dür kilbar boltuıai kemen ... sanan sayıysayar, ...tung bičijü jabdaysan*¹⁴ *ügei.*
 1780: *alba aqui kereg budulıyan-u tula. basa olju bičigsen ügei*
 1824: *yirü nutuy-yin řajartur kereg budalıyan ülemji bolju. tung bičijü jabdaysan ügei.*
 1780: *alban-u kereg-i ıııaysan čilüge-degen. sayı ene bičig-i olju jokıyayad.*
 1824: *alban-u kereg sidkeküi qoyorundu-dur tür čilüge olju. sai bayıčayan üjejü*
 1780: *orui-dayan*¹⁵ *manju üge. daray-a anu kitad üge. neng daray-a mongyol üge ...bičijü yaryayad*
 1824: *degedü-dür mongyol üge. mön daray-a mangju üge jiysayan bičijüküi.*
 1780: *mongyol üsüg-ün mön dürsü ba mongyol ügen-ü uy sanay-a-i kilbar-a uqatııai ...medetügei kemen bičibeı.*
 1824: *mangju üge-yi yeke tölıb-i darui olju medeküi-dür*¹⁶ *kilbar suratuıai kemen ... jokıyan bičigsen buyu*
 1780: *iji bolıaju tobkibai.*
 1824: *iji neyilegülın*¹⁷ *tobkiba.*

1780 оны толь бичигт оршлын дараа манжийн “Арван хоёр толгой үсэг”-ийг тавьсан байдаг. Тэгвэл Дондовдорж оршилынхоо хойно мөн өөрийн баримталсан «монгол үсгийн нэг зуун толгой»-г оруулжээ. Иймээс Дондовдорж тайж Жин Зай гүнгийн толийг ашиглан монгол үгийг монгол үсгийн толгойгоор ялган эхэнд тавьж манж орчуулгыг нь доор нь бичсээр ийнхүү монгол толгойтой толь болгосон нь илэрхий байна. Харин 1780 оны толь бичиг дэх хэлзүйн холбогдолтой ажиглалт ангиллын хэсгийг толь бичигтээ тусгаагүй орхисон бололтой.¹⁸

¹² Дашрамд өгүүлэхэд, Сайшанга-гийн бичсэн *Монгол үсгийн журмыг салгасан бичиг, жич хуульт дүрэм бичиг* (*mongyol hergen-i jurıan-be farsalaha bidhe, jai qoolingıa durım bidhe*)-ийн оршлын үг нь түүний ашигласан зохиол болох Жин Зай гүнгийн “Гурван зүйлийн үг хадмал үзэхүйд хялбар болгосон бичиг” (*ilan hačin-i gisun qatčibuha tuwara-de ja obuha bidhe*)-ийн оршилтой мөн л баахан төслүү мэт санагднам.

¹³ *sanaday abču* гэдэг үгийн манж нь үгчилбэл, *sanan sayıysayar* гэж орчуулах үг бий.

¹⁴ [=jabduysan]

¹⁵ Манж нь үгчилбэл дээдэд хэмээх үг бий.

¹⁶ Манж нь үгчилбэл мэдтүгэй хэмээх үг бичжээ.

¹⁷ Манж нь үгчилбэл иж болгож гэсэн үг бичжээ.

¹⁸ Тус зохиолын хоёрдугаар дэвтэр олодоогүй тул энэ талаар шууд хэлэхэд бэрх юм.

Энэхүү монгол манж толь бичгийг толилсон зарим онцлогийг дурдъя.

- Тус толь бичигт толгой үгийг үсгийн дарааллаар толгойлохдоо удаах үсгүүдийн дэсийг ер харгалзаагүй байна. Ингэснээр монгол үгийг зөвхөн тэргүүн үеэр нь бүлэглэн нэг дор оруулсан байдалтай болжээ. Үүний улмаас нэг ижил үгээр эхэлсэн холбоо үгс тухайн толгойн хэсэгт энд тэнд салж орсон байна. Жишээ нь, *bay-a kebeli*, *bay-a ebketel*, *bay-a quriyungyui*, *bay-a torjumsuy*, *bay-a jergeten* хэмээх үгс нэг дор орж, өөр хорин гурван толгой үгийн дараа *bay-a abay-a* хэмээх үг, түүнээс хойш дөчин нэгэн толгой үгийн дараа *bay-a qomsu*, *bay-a abay-a bergen*, *bay-a abay-a nar* хэмээх үгсийг бичсэн гэх мэтээр нийт *bay-a* гэдэг үгээр эхэлсэн хорин таван холбоо, хоршоо үгийг арван гурван газар салгаж оруулсан байна.

- Өмнөх манж толь бичгүүдийн нэгэн адил дан үг төдийгүй идэвхтэй хэрэглээний чөлөөт холбоо үг, нэр томъёоны чанартай тогтвортой холбоо үг, сул үг, аялга үг, дагавар үг зэргийг толгой үгээр авчээ.

- Тус тольд монгол толгой үгийн хажуугаар мөр ацлуулан хэд хэдэн монгол үгийг зэргэд тавьсан газар цөөнгүй. Тэдгээр нь цаанаа нэг л манж үгээр орчуулагдах үгс байна. Манж монгол тольд ижил үг хийгээд олон утгат үгийг цөм нэг толгой үг болгон онолдох орчуулга үгсийг доор нь жагсаах юм уу, таслалаар зааглан цувуулж бичсээр ирсэн уламжлалтай бөгөөд эл гар бичмэлд урьдын толь бичгийг шууд тонгоруулан сийрүүлэхдээ нэг манж үгэнд онолдох монгол үгсийг салгалгүй хамт тавьжээ. Түүнийгээ онолдох үг тус бүрийн байвал зохих тухай тухайн толгойд давтан бичсэн байна. Жишээ нь, “*kü*” толгойг хэсэгт *küliyemüi*, *kürtemüi*, *tosumui*, *ejelemüi*, *edlemüi*, *dayayamui*, *amsumui*, *ülemüi* – *alimbi*; “*e*” толгойг хэсэгт *ejelemüi*, *küliyemüi*, *kürtemüi*, *tosumui*, *edlemüi*, *dayayamui*, *amsumui*, *barimui*, *ülemüi* – *alimbi*; “*a*” толгойг хэсэгт *amsumui*, *küliyemüi*, *barimui*, *ejelemüi*, *edlemüi*, *dayayamui*, *tosumui*, *ülemüi*, *kürtemüi* – *alimbi* хэмээн толилжээ. Гэвч зарим манж үгийн хэд хэдэн оноолтыг бүрэн оруулсангүй. Жишээ нь, *urgunjembi*-гийн дээр *bayarlamui* гэж тавиад ихэнх тольд байдаг *bayasumui* гэдгийг тавьсангүй.

- Дээрхээс гадна холбоо үгийг толгой үгийн зайд багтаахын тул мөр ацлан бичжээ.

- Тус тус толгой үг болговол зохих зарим холбоо үгийг эхний тодотгол үгийг нь барьж нэг толгойд мөр ацлуулж бичжээ. Жишээлбэл, уулын хормой, уулын ар, уулын хамар гэсэн гурван үгийг нэг толгойд *ayulan-u qormai / aru / qabar* – *alin-i saiha /sončo / oforo* гэх мэт.

- Нэр ба үйл үгийн хэлбэрүүдийг толгой үг болгон оруулжээ. Энэ дашрамд дурдахад, Манж-Монгол толь бичгийн зүйлд үйл үгийг одоо цагийн –*mbi* (-*mui*, -*müi*) хэлбэрээр биежүүлэн толийн үг болгохын сацуу, мөн зарим үгийг үйлийн өнгөрсөн цагийн нөхцөлийн -*qa*, -*ke*, -*qo* (-*ba*, -*be*, -*bai*, -*bei*); -*qabi*, -*kebi*, -*qobi* (-*juqui*, -*jüküi*) хувилбар, нөхцөл үйл үгийн урьдчилах ба зэрэгцэх нөхцөлийн -*pi* (-*γad*, -*ged*, -*ju*, -*jü*, -*čü*, -*čü*) хувилбараар хэлбэржсэн үгсийг толгой үг болгон оруулдаг уламжлалтай. Энэ нь өнгөц үзвэл орчин цагийн толь бичгийн шаардлагад нийцэхгүй мэт боловч угтаа манж хэлний зөв бичих зүйг толиор журамлан байсан хэрэгцээ шаардлагатай холбоотой. Манж хэлэнд дээр дурдсан хэлзүйн хэлбэр, түүний хувилбаруудыг ямар үгэнд залгах тухайд хатуу дүрэмгүй, гагцхүү толиор нэг мөр болгон бичдэг байв.¹⁹ Нэр үгийн тухайд олон тоот хэлбэр, зарим төлөөний үгийн тийн ялгалтай хэлбэр зэргийг мөн толгой үг болгодог нь энэ тольд эрхгүй тусгагджээ.

¹⁹ М.Баярсайхан, Т.Отгонтуул, *Монгол-Манж толь /УБ 1997/-ийн “Тодруулга”-д буй.*


- Эргэлзээтэй бичлэг буй. Жишээ нь, *edegeer* хэмээх үгийн манж орчуулга *erse* гэжээ. Зүй нь *ese* болно. *umuhun tuheke* хэмээх манж үгийн дээр *bayilduba* хэмээх толгой үг бичжээ. Зүй нь *balidaba*²⁰ гэж байхыг ийнхүү ташаарчээ.

- Зарим толгой үгийг дахин давтжээ. Жишээ нь, *egün-eße* – *ereçi* хэмээх үг өмнө хойно хоёр удаа толгой үг болж орсон байна.


Ийнхүү эргэж нягтлаагүй зүйлүүд байгаа болон толь бичгийн нэрийг эцэслэн тогтоогүй зэргийг үзвэл энэ гар бичмэл эцсийн хувилбар биш байж болох юм. Энэ толь бичиг хэр тархаж байсан, өөр хуулмал болон хувилбар эх бий эсэх, толь бичигтэй холбоотой ямар нэгэн айлтгал, албан баримт гарч байсан эсэх талаар одоогоор мэдээ баримт олдоогүй байна. Бодвоос, зохиогч толь бичгээ бичсэнээс хойш хоёр жилийн дараа нас барсан нь уг зохиолыг нэмж засан тархааж чадаагүйн нэгэн шалтгаан болов уу. Бидний гарт буй энэ дэвтэр бол Дондовдоржийн өөрийн бичсэн жинхэнэ эх бичгээс хожим ойр төрлийн юм уу нутгийн бичээчээс сийрүүлэн хуулсан хуулбар эх байх магадлал их байна.

Өнөө хир мэдэгдээд буй монгол хүн зохиосон юм уу оролцсон манж, монгол хэлний уламжлалт толь бичгүүд нь нэг бол Чингийн үед манжийн хааны зарлигаар Бээжинд сууж бичсэн, эсвэл улс үндсээ гэх үндэсний ухамсар, зориг идэвхжээд байсан Богд хаант Монгол улсын үед Ар, Өвөр монголын бичгийн түшмэдээс өөрсдийн санаачлагаар бичсэн зохиолууд байдаг. Тэгвэл Чингийн төр төвшин цаг үед Халхын нутагт монгол хүн өөрийн санаачлагаар монгол манж толь бичиг хийж байсныг харуулах одоогоор мэдэгдэж буй гагц баримт болсны хувьд уг толь бичиг нь сонирхолтой бөгөөд Монголд өөр их бага иймэрхүү толь бичиг гарч байсныг үгүйсгэх аргагүй билээ.

²⁰ *балыдах* гэдэг нь айж цочсоны улмаас ухаанаа олохгүй, хөл хөдлөхөө байхыг хэлсэн үг.



1. Дэвтрийн дотор тэргүүн нүүрт толь бичгийн гарчгийг тавьсан нь



2. Гуравдугаар нүүр дэх гарчиг

The image displays six lines of handwritten musical notation in Mongolian script. Each line begins with a large, stylized symbol, likely a clef or a specific rhythmic indicator. The notation consists of various symbols, including circles, vertical lines, and curved strokes, which represent musical notes and rests. Some symbols are accompanied by small vertical annotations or markings. The notation is arranged in a structured, horizontal format across the six lines.

4. Толь бичигт баримталсан монгол үсгийн толгой



5. Толь бичгийн “а” толгойт хэсгийн нэгэн хуудас